

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагад 2024 оны жилийн эцсийн байдлаар ирсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2025 оны 01 дүгээр сарын 06

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн албаны тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” систем ашиглах журам”, MNS 5140-1:2021: Баримт бичиг. 1-р хэсэг. Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт, MNS 5140-2:2021: Баримт бичиг. 2-р хэсэг. Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага, MNS 5140-3:2021: Баримт бичиг. 3-р хэсэг. Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага болон бусад холбогдох эрх зүйн актуудыг тус тус үндэслэл болгосон.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагад 2024 оны жилийн эцсийн байдлаар ирсэн (өссөн дүнгээр) албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, баримт бичгийн стандартыг мөрдлөг болгож, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн болон бусад зөрчлийн тоог бууруулахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэв.

“Бүрэн хэрэгжсэн”- холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь буюу (90-100% хүртэл);

“Хэрэгжих шатанд”- тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-90 хүртэл хувь);

“Хэрэгжилт хангалтгүй”- тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-50 хүртэл хувь);

“Хэрэгжээгүй”- тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-10 хувь);

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Онцгой комисс, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа 107 байгууллагад *Edoc.ulaanbaatar.mn* нэгдсэн системээр 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний хооронд нийт **39847** албан бичиг ирснээс хариутай **5008**, хариугүй **34839**, үүнээс хугацаандаа шийдвэрлэсэн **39581**, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн **266**, судлагдаж байгаа **0** албан бичиг байсан бөгөөд шийдвэрлэлт **98.63** хувьтай, шийдвэрлэлтийн дундаж хоног **5.07** (хоног) байна.

Дүүргийн хэмжээнд нийт зөрчил тооцогдсон **1376** (хугацааны зөрчил 184, стандартын зөрчил 185, систем ашиглалтын зөрчил 40, явцын тэмдэглэл хугацаанд нь хөтлөөгүй зөрчил 967) албан бичиг байгаа нь нийт албан бичгийн **3.45** хувийг эзэлж байна.

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР, ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГАД
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ИРСЭН АЛБАН БИЧГИЙН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн албан бичгийн тоо	Нийт шийдвэрлэсэн албан бичгийн тоо		Үүнээс	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлтийн дундаж хоног	Шийдвэрлэлтийн /хувь/
			Хариу -тай	Хариу- гүй	Хугацаа хэтрүүлж шийдвэр -лэсэн			
1	2	3	4	5	6	7	8	9
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	749	40	709	0	0	5.30	100.0
2	Засаг даргын Тамгын газар	6533	407	6126	25	0	5.13	98.99
3	Хэлтэс, алба	12631	1738	10893	72	0	4.81	98.94
4	Хороод	8577	2051	6526	65	0	4.14	98.88
5	Сургууль	5116	198	4918	48	0	5.71	96.90
6	Цэцэрлэг	6241	574	5667	56	0	5.37	98.07
Дүн		39847	5008	34839	266	0	5.07	98.63

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 дахь хэсгийг үндэслэн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагад 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх (жилийн эхнээс өссөн дүнгээр) албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн дундаж **98.6** хувь буюу **"Бүрэн хэрэгжсэн"** гэж үнэлэгдсэн байна.